

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Батсайхан	Дугаар	L158
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Галуут
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Ловон лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Чин сүжигт Номун хааны хийд	Сүм хийдийн дугаар	БХГТ 090
Одоогийн сүм хийд	Чин сүжигт Номун хааны хийд	Сүм хийдийн дугаар	БХГТ 019
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 9-р сарын 7	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт байх Чин **сүжигт** номун хааны хийд

Асуулт:-Ингээд тус хийдийн ловон лам Батсайхан гуайгаас Чин сүжигт номун хааны хийдийн тухай түүхийг асууж ярилцъя.

Хариулт:-Монгол Улс орон даяар хөдөөний монгол улсад байсан хуучны болоод одоогийн сүм хийдүүдийнхээ үйл ажиллагаатай танилцаад үүнийг нь баримтжуулаад үүсэл хөгжлийг нь тодорхойлоод ингээд явж байгаа явдал талархаж байна.

Ингээд Чин сүжигт номун хааны хийд бол 1755 онд анх Лувсанноров Шарав гэгээн өөрийн шавь **Янжинсүхийнхээ** хамт энэ хүрээний газар ирж, хүрээ хийд байгуулахаар ирсэн байгаа юм. Энэ явцад Өндөр гэгээн, Заяын гэгээн, Лувсанноров Шарав гэгээн гурав бол халхын төвд орж дуган сүм хүрээ хийд байгуулна гэж гараад тэгээд Лувсанноров Шарав гэгээн бол энэ дээд Дүүрэн гэж газар анх хүрээнийхээ шавыг тавьж байсан. Шавыг нь тэр үед **Гомбо** сахиусны элч бараан шувуу авч яваад манай энэ байгаа Мандалын төвд орхисон. Тэгээд үүний хойноос ирж хүрээнийхээ анхны шавыг тавьж тэр үеийн **Дашдоо** өвгөнөөс таны энэ ар нутаг болох

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хоёр голын зааг Цагаан **баруутын** гол, Байдрагийн голын зааг хоёр голын **зоогонд** зааг нутаг үхрийн туламны арьсны чинээ газарт хүрээ сүмээ байгуулж хоёр голынх нь зааг нутгаар шавийн хошуугаа байгуулна гэж гадаргуугаа ингээд Номун хан гэгээнийг анх үүсгэн байгуулсан түүхтэй.

1920-иод он хүртэл Чин сүжигт номун хан гэгээн нь 7 үе дамжин төрсөн. Үе үеийн **гэгээдүүдийн** үйл ажиллагаа, хурал номын ажил, монголын бурхан шашны өв соёлд оруулсан хувь нэмэр, түүгээр ч барахгүй **Данжуур, Ганжуур** бүтээх үйл ажиллагаа нь ч гэсэн анхдугаар, хоёрдугаар хошуудын дунд номун хан **гэгээдийн** 3-р дүр оролцож байсан гээд. Номун хан гэгээний тухайн үед буддын шашны үүсэл хөгжилд оруулж байсан хувь нэмэр өндөр юмаа.

Тус хийд нь 700 гаруй **хуврагатай**, гэгээнээсээ гадна хоёр Бандид хувилгаан, Ялгасан гэгээн гэж хоёр сайхан том хувилгаан ламтай, ийм хурал номын иж бүрэн хэрэгсэлтэй дуган сүмтэй байсан байна. Тухайн хийд сүүлийн үе 1920, 1930-аад он **дамжсан** хэлмэгдүүлэлтийн нийт 18 дуган, 7 суварга байснаас зургаахан дуганы туурь үлдэж хоцорсон. Тэр зургаан дуганы дөрвийг нь тухайн үед дэлгүүр худалдаа, гарааш, номын сан, тосон завод, эмнэлгийн чиглэлээр ашиглаж байсан. 6 **дуганын** суурь 1990 оныг хүртэл бас л мөн салхи, шороо, тэр үеийн социализмын бүтээн байгуулалтын шуурганд өртсөөр бараг үгүй болдгийн даваан дээр 1990 онд дахин ардчилал хөгжиж, шашин шүтэх эрх чөлөө нээгдсэнээр тухайн хийдийн хурал номонд сууж байсан лав хуврагууд болох **Эдэнгийн** Содном миний багш, Гэндэн гуай, Санжаасүрэн гуай, Гомбосүрэнгийн Пүрэвдоо гэж Гандантэгчилэн хийдийн хуралд байсан манай багш ламтан эдгээр лам нар нутгийн сүсэгтэн олон мөн **Дашдоо** гүний лам нарын хамт 1990 оны 5 сарын 28-нд анхныхаа хурлыг хийж гэр барин дуган сүмийн үйл ажиллагаа дахин сэргээсэн юм.

Асуулт:-Тухайн дээр үедээ аль овоог тахидаг байсан юм бол?

Хариулт:-Чин сүжигт номун хан гэгээн нь дээшээгээ Цагаан **даваатын** голын **эхээд** Бүрэн хайрхан, Согоо хайрхан гэж хоёр сайхан хайрхан тахидаг. Мөн тэрнийг нь болохоор зүүн **дацангийн** лам нар тахидаг, мөн доошоо уруудаад **Ямбат** хайрхан, Сүмбэн **гэцэл** хайрханыг тахина, энийг нь баруун **дацангийн** лам нар тахина. Эндээ төвийнхөө хойд талын Гэнэн **цогтын** овоо, урд талдаа **Дашдоо** гүний савдаг, мөн Гүнэн **түмбэ**, доошоо шинэ үс Баяннуур гээд тахилгатай ийм уул **усуудыг** тахиж байсан байгаа юм.

Асуулт:-Төвдтэй холбоотой байсан уу?

Хариулт:-Төвдүүдтэй холбоотой байхаар барахгүй, Төвдөөс ном, гүрэм янз бүрийн шашин номын хэрэгслээ залах, авчрах, Төвдөд бүр Далай **ламуудыг** сонгоход хүртэл Номун хан гэгээн өөрсдийнхөө санал оноог оруулж татгалзаж байсан тийм түүх нь ч байдаг. Ер нь монголын шашин буддын шашны хөгжилд хичнээн ямар байр суурьтай вэ гэдгийг бас харуулан түүнийхээ төлөө тэмцэж, түүнийхээ төлөө үйл хэрэг бүтээж, түүгээр ч барахгүй **Ганжуур, Данжуур** бүтээж явсан түүхэн ач холбогдолтой 7 сүмбэн зохиолтой тийм Номун хан гэгээний үе дамжсан лам нар байдаг юм билээ.

Асуулт:-Овоогоо ямархуу зан үйлээр хэдийд тахидаг байсан?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Хавар, зуны сар, хаврын сүүл сар, зуны эхэн сараар дамнуулаад дацан **дацангийн** лам нар гараад, тухайн тухайн хүрээ хийдийн овоонуудаа тахиад нутгийн сүсэгтэн олны хамтаар. Гэнэн **цогтын** овоог бол овоохон нэг бүтэн шүүс , цагаан морь уралдуулах ийм тахилгатай, доор нь 2 талынх нь үзүүрт нэг нь **Цагаан манзуширийн** орон гээд эрэгтэй хүүхдүүд тахидаг, уралдуулдаг. Нөгөө талд нь **Нархажидийн** орон гээд эмэгтэй хүүхдүүд уралдуулж тахидаг. Дээшээ **Бүрэнхайрхан, Согоохайрхан** болохоор үхэр уралдуулж тахидаг, шүүс залдаг, **Ямбат** хайрханыг одоогоор бол 4 сумын дунд, тухайн үед бол Номун ханы нутаг Заг, Байдраг, Галуут, Бууцагааны уулзвар **Ямбат** хайрхан гэж сайхан тахилгатай уулыг тал талаасаа бүрдэж тахиж байсан түүхтэй. Одоо хамгийн онгон байгаа тахилга маань бас л эвдэж сүйтгэж байгаад харамсаж л байна.

Асуулт:-Майдар эргэх ёслолын тухай та ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Номун хан гэгээн бол **майдраараа**, түүгээр ч барахгүй ер нь Баянхонгор аймагтаа **Дашдоо** гүний хийд бол **зурмал**, дэлгэмэл **майдраараа** монголд алдартай байсан байгаа юм тухайн үед. Манайх бол **Майдарын** ногоон морьтой, тэрэгтэй, **Майдар** эргэх ёслол зан **заншлаараа онцлог**. Хавь ойрын хүрээ **хийдүүдийнхэн** ирдэг, зуны дунд сарын 15-нд тахидаг, цамын 128 дүр гардаг, **Майдар** эргэх гэж 2, 3 өдрийн юм болдог, 4 талдаа үдэлдэг, маш том гоё **Майдартай** байсан. Одоохон 1990 оноос хойш манай багш нар үе залгамжлуулаад бид нар тэрэг хийгээд, мөн тэр үеийн ногоон морьтой **түүгээрээ** 2001 оны Номун хан гэгээний ойн ажил хүртэл тэр болгон **Майдараа** эргэж байсан. Одоо ч эргэдэг.

Асуулт:-Ном судраа хэвлэдэг, бар,хэвлэлийн талаар ярьж өгнө үү.

Хариулт:-Номын барын хувьд алдартай. Нэгдүгээрт, манайх өөрөө модон бартай, тэр үед манайх энд номоо хэвлээд хэвлэсэн номоо бусад хүрээ хийдүүдийг хангаж байсан. Өөрсдөө үе дамжсан 3, 4 үеийн уран зураач, сийлбэрч хүмүүс байсан. Манай гэгээн өөрөө маш их бурхан бүтээдэг, зурдаг, сийлдэг, ийм уран хүн байсан. Түүгээр ч барахгүй манайх чинь Гүр дуугаараа алдартай. Тэр дууг бол Эрдэнэчимэг судлаад докторын зэрэг хамгаалсан. Гүр дуугаар Номун ханы хийд монголын нэг үеийн төлөөлөл, гайхамшиг гэж хэлж болох юм.

Асуулт:-1990 оноос сэргээгдсэнээс хойш ямар үйл явдал болсон, одоо сүм хийдийн байдал ямархуу байдалтай байгаа вэ?

Хариулт:-1990 онд тухайн үеийн лам хуврагууд маань сүм хийдийг маань сэргээж өгөөд хүрээ хийдийн үйл ажиллагаа бол 2001 он хүртэл үндсэндээ өдөр болгоны хуралтай, сар болгон уншдаг номоо уншдаг, хавар намарт нь овоо хангайгаа тахидаг, даллагаа авдаг, сар болгон сороо залчихдаг, ер нь хурал номын ажиллагаа өв тэгш, 10 хэдэн ламтай ингэж явж ирлээ.

1990 оны үед нэгдэл тарснаар Номун ханы хийд 100 гаруй бог малтай, 20 гаруй бод малтай, түүгээрээ 2001 оныг хүртэл бид нар үйл ажиллагаагаа үргэлжлүүлээд явуулсан. Тухайн хийдийн үйл ажиллагаа явуулах сан хөмрөгийн хувьд хүн зон цөөхөн ийм байдаг. Тэгээд хүрээний үйл ажиллагаа бол үндсэндээ өөрийнхөө сан хөмрөгөөр овоо хангайгаа тахиж, хурал номоо дэмжиж зохион байгуулах ийм үйл ажиллагаатай явсаар 2001 оноос хойш, 2002 оны зун зудны үеэр мал үндсэндээ байхгүй болсон. Тэгээд нутгийн сүсэгтэн олны хүч

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

дайчилгаан дунд л хүрээ хийд цаашдаа яаж явах нь тодорхой болсон. Энэ үед Чин сүжигт номун хан хийдийн үндсэн шүтээн болох Гомбо сахиус, **Майдар** бурхан, 64 **бурхадыхаа** хамт 2 гүнгэрваатай **бурханаа** 1998 оны 12 сард **хулгайд алдсан**. Өнөөдөх маань өдий хүртэл олдоогүй. **Өнөөдхийн** шуурганд хэн өртсөн, би л өртсөн. Тэгээд хүрээ хийдийн эд зүйлийг идсэн, уусан, хулгай хийгээд бурхан тахилаа авчихсан ч юм шиг нэгдүгээрт ярьдаг.

Тэр гэгээний энэ үйл ажиллагаанууд нь, дээрээс нь сан хөмрөг байхгүй, тэгээд сэтгэл зүйн ийм дарамттай ийм үед бол хий хоосон хэлмэгдэж суугаад 4 жилийн нүүр үзлээ. Тэгээд өнөөдөр үйл ажиллагаа явуулах боломж алга. Цаашдаа хүрээ хийдийнхээ үе үеийн **гэгээдүүдийнхээ** хойч болох гэгээнийхээ дүрийг тодруулах гэж оролдож байна. Манай хурал ном хүрээ хийдийг анх үүсгэн байгуулсан Пүрэвдаваа багш маань Хархоринд сууж байна. Эдгээр лам нар маань эндээ ирээд хуучин ном уншлагынхаа юмыг дахин сэргээгээд сүсэгтэн олондоо ч зөв учир начрыг нь тайлбарлаад бурхан тахилыг нь ч олоод ингээд буцаад хөгжихөд бол 2003 оны соёлын сангийн **хөрөнгөнөөс** сэргээж босгосон 100 сая **төгрөгний** хөрөнгө оруулалттай дуган сүмийн хувьд бол үнэхээр сайхан **байнаа**. Хурал номонд оролцдог, уншдаг ном, хэрэглэдэг хэрэгсэл, энэ зүйл нь чөлөөтэй хангалттай. Хуралд суух лам нарын хувьд одоогоор шашны дунд сургууль, шашны дээд сургуульд суугаад байсан лам нар алга. Ер нь Гандантэгчилэн хийдийн шашны дээд сургууль би эчнээгээр төгссөн хүн. Миний 3, 4 шавь ч гандангийн харьяа **дацангуудад** жил жил хуралд суугаад ирсэн улсууд. Эдгээр лам нарыг санхүүгийнх нь ч талаар, шашин номынх нь талаар дэмжээд туслаад ингэх юм бол цаашдаа хурал номоо хурах боломжтой.

Асуулт:-Өөрөө эндээс ямар ямар юм шилжүүлсэн гэлээ, Дүрслэх урлагийн музейд?

Хариулт:-Энэ жил манайх хүрээнийхээ хэрэм дотроо 4 дугантай, хэрэмний гадна 2 дуган маань мөн л хэлмэгдээд устаад үгүй болоод байна. Энэ **нөхцлөөс** болж бид нар зүүн дуганыхаа дотор талыг хуучны сайхан **тансаг** зураг байдаг. Энэ зураг нь сүйрээд алга **болчихоос** нь өмнө гээд Соёлын сангийн салбар, Түүх соёлын дурсгалт зүйл сэргээн засварлах хүмүүс энүүгээр явахаар нь тэд нарт уламжилж, хэлж ярьж байгаад энэ жил дүрслэх урлагийн музейд шилжүүлэн байрлуулахаар нэг талынхаа хананы зургийг явуулсан байгаа.

Тус хийд 1990 оноос хойш үйл ажиллагаанд өргөн дэлгэр явж байх энэ үедээ хийж бүтээсэн зүйлийн талаар товч хэлье. 1991 онд сумын нэгдэл дундын барилгынхан сүсэгтэн олны хандиваар нэг дуганыг сэргээн засварласан. Улаанбаатар хотод байгаа нутгийн зөвлөлийн ахан дүүс нар тухайн сүмийн дотор талын хурал номын ширээ сандал, бурхан тахил залах лангуу гэх зүйлүүдийг бүтээж авчирч өгсөн байдаг юм. Дараа нь 2001 онд Монгол улсын соёлын сангийн хөрөнгөөр 3 дуган сэргээн засварласан, 130 сая **төгрөгний** хөрөнгө оруулалттай. Мөн 2003 онд аймгийн соёлын хэлтсийнхэн соёлын сангийн хөрөнгөөр 3 сая 500 мянган төгрөгөөр үүдний дуган барьж өгсөн. Баянхонгор аймгийн нутгийн зөвлөлийн дарга **Ишдэлэг** гэж хүний 1 сая **төгрөгний** бүтээлээр Номун хан гэгээний шуумал дүрийг бүтээсэн. Урлахуй ухааны багш Пүрэвбат багшийн Чин сүжигт номун хан гэгээний анхны бурханчилсан дүрийг бүтээж хандивлаж залсан.

Асуулт:-2003 онд тийм ээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тийм. Мөн 2003 ондоо манай хийдийг үүсгэн байгуулсан Гомбосүрэнгийн Пүрэвдаваа гээд манай хамба багш мөн **Ганжуур, Данжуур** судар залж өгсөн. Мөн 2003 оны Номун хан гэгээний 300 жилийн ойн ажиллагааг аймаг, сумын комисс ёслол төгөлдөр хийж, Номун хан гэгээнийхээ ойг тэмдэглэсэн. Мөн Номун хан гэгээний зурмал дүр, Номун хан гэгээний тухайн дээр үед байсан тэр бурханчилсан бүтээлүүдийг ч гэсэн, дуган сүмийн зургуудыг ч гэсэн зурж бүтээж залсан юмнууд байгаа.

Ингээд хийдийн тухай товчхон ярихад ийм байна. Ер нь монголд байгаа буддын шашны өв залгамжлах ёс эхлээд 17 жилийн нүүр үзлээ, бид 250-иад жилийн түүхтэй энэ шашныг 70-аад жил байхгүй болгоод дахин сэргээгээд 17 жил болоход багагүй хугацаа. Тэгээд одоо ийм сайхан дуган сүмүүд сэргээн засварлагдаад нэлээн лам хуврагууд ном сурч боловсроод одоо нөгөөдүүл нь зарим нь эргээд байхгүй болоод нөгөө дуган сүмүүд нь эргээд устаад шашны их урсгал орж ирээд **нөгөөдөхийг** сүйтгэж үймүүлээд лам **хуваргынх** нь сэтгэл санааг үймүүлж байна. Дуган сүмийг нь устгаж байна. Овоо хангайг нь нурааж байна. Энэ мэтчилэнгийн үйл ажиллагаанд одоо эцэс тавих цаг болсон. Буддын шашныг хөгжүүлбэ, буддын шашны зан заншлыг монгол хүмүүсийнхээ үндэсний бахархал болгож үлдээе гэвэл бурхан шашинтны төвийн нөхөд, ахан дүүс, лам **хуварга**, багш та бүхэн маань хөдөө орон нутагт байгаа сүм хийдүүдийнхээ лам, **хуварга**, сүсэгтэн **олонтой** тулж ажиллах цаг болжээ гэдгийг хэлмээр байна.